



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/814

Булган сум

Аймгийн “Шилдэг өвлөн уламжлагч”-ийг
урамшуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/705 дугаар захирамжаар батлагдсан “Соёлын биет бус өвийг уламжилж, сурталчлан түгээн дэлгэрүүлсэн өвлөн уламжлагчид урамшуулал олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Соёлын биет бус өвийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан Сайхан сумын өвлөн уламжлагч Цэрэнгийн Батсүрэнд журмын дагуу урамшуулал олгосугай.

2. Урамшуулалд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325011195

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж